Улсын бүртгэлд 2011 оны 12-р сарын 01-ны
өдрийн 3297 дугаарт бүртгэв.
Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам

# МОНГОЛ УЛСЫН
# БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
# САЙДЫН ТУШААЛ

2011 оны 10 сарын 10 өдөр　　　Дугаар А-342　　　Улаанбаатар хот

Агаарын чанарын хяналт шинжилгээний
ажлын үйлчилгээний хөлс, хураамжийн хэмжээ
тогтоох тухай

"Агаарын тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дах хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Агаарын чанарын мэргэжлийн албаны дүгнэлт гаргуулах ажиллагааны үйлчилгээний хөлс, хураамжийн хэмжээ"-г хавсралтаар баталсугай.

2. Дээрх үйлчилгээний хөлс, хураамжаас орсон орлогыг Цэвэр агаарын санд төвлөрүүлэхийг Агаарын чанарын мэргэжлийн албаны дарга /С.Энхтүвшин/-д үүрэг болгосугай.

3. Цэвэр агаарын санд агаарын чанарын хяналт шинжилгээний ажлын үйлчилгээний хөлс, хураамжийн орлогоос орсон орлогыг жил бүр Агаарын чанарын албаны чадавхийг бэхжүүлэх, агаарын бохирдлын чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажилд зарцуулж байхыг Цэвэр агаарын сангийн гүйцэтгэх захирал /Н.Хүрэлсүх/-д зөвшөөрсүгэй.

САЙД　　　　　Л.ГАНСҮХ

0324

Байгаль орчин, аялал жуулчлалын
Сайдын 2011 оны 10 сарын 10-ны өдрийн
А-342 дугаар тушаалын хавсралт

## Агаарын чанарын хяналт шинжилгээний ажлын үйлчилгээний хөлс, хураамжийн хэмжээ

| Тодорхойлох үзүүлэлтүүд | Хэмжилт хийх аргачилал | Үнэ, төгрөгөөр |
|---|---|---|
| Орчны агаарт хүхэрлэг хий, ($SO_2$) | Нэг удаа /20 минут/ | 6000 |
| | Хоногт /24 цаг/ | 7000 |
| Орчны агаарт азотын давхар исэл ($NO_2$) | Нэг удаа /20 минут/ | 6500 |
| | Хоногт /24 цаг/ | 7500 |
| Орчны агаарт нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) | Нэг удаа /10 минут/ | 4500 |
| | Хоногт /24 цаг/ | 6000 |
| Орчны агаарт PM-1.0 (5 минутын зайцтай) | Нэг удаа /60 минут/ | 30000 |
| | Хоногт /24 цаг/ | 50000 |
| Орчны агаарт PM-2.5 (5 минутын зайцтай) | Нэг удаа /60 минут/ | 30000 |
| | Хоногт /24 цаг/ | 50000 |
| Орчны агаарт PM-10 (5 минутын зайцтай) | Нэг удаа /60 минут/ | 30000 |
| | Хоногт /24 цаг/ | 50000 |
| Орчны агаарт нийт тоос TSP нэг удаагийн сорьцонд (их эзэлхүүний арга) | Нэг удаа /30 минут/ | 20 000 |
| | Хоногт /24 цаг/ | 30000 |
| Мөнгөн ус тодорхойлох /зөөврийн багажаар/ | Нэг удаа /20 минут/ | 4500 |
| | Хоногт /24 цаг/ | 10000 |
| Хүнд металл тодорхойлох /нэг элемент/ | | 17000 |
| **Автомат анализатораар хяналт шинжилгээ хийх** | | |
| Тодорхой цэг дээр 24 цагийн турш 5 минутын зайцтайгаар $O_3$, CO, $NO_x$, $SO_2$, тоосонцор, цаг агаарын үзүүлэлтүүд | Хугацаа /24 цаг/ | 250000 |
| **Хаягдал утааны хийн хэмжилт хийх** | | |
| Нэг удаа $O_2$, CO, NOx, $CO_2$, $SO_2$, | Нэг удаа /3-4 цаг/ | 100000 |
| Хаягдал утаанаас гарч буй нийт тоос | Нэг удаа /20 минут/ | 50000 |
| **Автотээврийн хэрэгслийн яндангийн хаягдал утаанд хэмжилт хийх** | | |
| Бензин хөдөлгүүртэй | Нэг удаа | 10 000 |
| Дизель хөдөлгүүр | Нэг удаа | 10 000 |
| Дүгнэлт гаргах | Нэг удаа | 30 000 |